

Анхдугаар спартакиадын аварга шатарчин

хуучин танил



Вандаа овогт Гончигийн Чилхаасүрэн

1927 онд Сүхбаатар аймгийн Халзан суманд төрсөн. Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит офицерын сургууль, Эдийн засгийн дээд сургууль төгссөн, цэргийн ангид улс төрийн орлогч, Сүхбаатар аймгийн намын хороонд хэлтсийн эрхлэгч, МУИС-д багш, тэнхмийн эрхлэгч, деканаар ажиллаж байсан, Алтан гадас одон, байлдааны болон ойн медиалуудаар шагнагдсан, Ардын боловсролын тэргүүний ажилтан, бэлтгэл ахмад, дэд профессор, шатрын спортын мастер цолтой.

- 1961 онд зохиогдсон МБАТ-ий анхдугаар спартакиадын талаар Та дурсамжаа ярина уу.

Энэ спартакиадын шатрын тэмцээнд 18 аймаг, нийгэмлэг, их дээд сургуулиудаас шалгарсан И.Ёндон-Осор, Ж.Дугар, Н.Намжил, Ц.Жүгдэр, Д.Цэрэндагва, Ш.Пүрэвжав, П.Төмөрбаатар нарын зэрэг мастерууд оролцсон 28 шатарчин өрсөлдөж би түрүүлэн алтан медаль хүртсэн, улмаар 7 спартакиадад оролцон 2 мөнгө, нэг хүрэл медаль нэмж авсан.

- Шатрын бусад тэмцээнд ямар амжилт үзүүлж байв?

УАШТ-д 9 удаа оролцож 1960 онд түрүүлсэн, 1964 онд социалист орнуудын армийн аварга, МҮЭ-ийн удаа дараагийн аварга болж байсан, Дэлхийн шатрын олимпиадад 4 удаа, оюутныхад 3 удаа оролцсон, Ахмад шатарчдын УАШТ-д шагналт байрт тогтмол шалгарч ирсэн.

Ахмад мастер Г.Чилхаасүрэнгийн тоглосон олон сайхан өргүүдийн нэгийг сонирхуулъя.

Г.Чилхаасүрэн – П.Төмөрбаатар

Улаанбаатар. 1971 он



1. e4 c5 2. ♘f3 d6 3. d4 cd 4. ♘d4 ♘f6 5. ♘c3 a6 6. ♗g5 e6 7. f4 ♗e7 8. ♖f3 ♖c7 9. 0-0-0 ♘bd7 10. g4 b5 11. ♗f6 fg (11... ♗f6 буюу 1... ♘f6 гэвэл 12. g5 гэнэ) 12. g5!? fg 13. f5 ♘c5 (хэрэв 13... ♘e5 гэвэл дараах хурц тоглолт гарах байв: 14. ♖h5 b4 15. fe bc 16. ef ♗f8 17. ♖h6 ♗f7 18. ♗e2 гээд довтолгоонтой) 14. fe fe 15. ♖h5 ♘d8 16. e5! d5 17. ♗h3 b4 (диаграмм) харын боднуудын хөллөгөө муу, ноён нь төвд байгааг ашиглаж бод хаян довтолжээ: 18. ♘:d6! ♗e6 19. ♘d5 ♖e5 20. ♘e6 ♗d6 (20... ♖e6 21. ♘f4) 21. ♗he1 ♖h2? 22. ♖g5 ♗e8 23. ♗g4 ♗f7 24. ♖f6 ♗g8 25. ♗e6 ♘e6 26. ♗g1 ♗g3 27. ♘e7 #

- Та бүх насаараа багшийн болон удирдах ажил хийж, МУИС-ийн дасгалжуулагч, Хоршоолол нийгэмлэгийн зөвлөх байсан тул бахархах олон шавьтай биз ээ?

Ер нь олон шавьтай, нарийн тоолж үзээгүй юм байна. УИХ-ын гишүүн С.Ламбаа, Б.Эрдэнэсүрэн, Да.Ганболд, Ши.Батбаяр нарын зэрэг төр, нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэд, гавъяатнууд болон ОУМ С.Хандсүрэн, Ц.Батцэцэг, ФМ Ч.Хүрэлбаатар, СМ Ш.Дэчин, Г.Баярмаа, Г.Оюунчимэг, М.Хишигбаяр зэрэг шатарчдыг нэрлэе.

- Монгол оронд шатрын спортыг хөгжүүлэх талаар зүтгэж буйг Таны бичсэн номнууд илтгэдэг гэж бодож байна

Залгамж үедээ гарын авлага үлдээе гэж залуудаа бодож байснаа саяхнаас л хэрэгжүүлж байна. Шатрын уран сайхны нүүдэл (2002), Шатрын сурах бичиг (2003), Шатрын төгсгөлийн онол (2005), Шатрын тоглолтын дунд үе (2007) ном бичиж хэвлүүлсэн, цаашид бас хийх ажлын санаа байгаа. Энэ боломжийг ашиглан залуучууд болон өсвөр үеийн шатарчиддаа онолын бэлтгэлээ сайн базааж байнгын бэлтгэлтэй байхыг зөвлөө.

Залуугийн цог жавхаагаар гялалзаж яваа хамгийн ахмад мастер Танд урт удаан наслан уран бүтээл их туурвихын өрөөл дэвшүүлье.

Ярилцсан Л.ТОГООХҮҮ

